

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



2017

# ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ




Улаанбаатар хот

2018 он

## 1. Бүртгэгдсэн зам тээврийн осол

Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)-ын Замын цагдаагийн албаны мэдээгээр 2017 онд 36591 зам тээврийн осол<sup>1</sup> бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 10121 (21.7%)-ээр буурав. Нийт зам тээврийн ослын 89.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Зураг 1.1. Бүртгэгдсэн зам тээврийн осол, 100 000 хүнд ногдох зам тээврийн осол




Бүртгэгдсэн нийт зам тээврийн ослын 88.8 хувийг эд материалын хохиролтой осол<sup>2</sup>, харин 11.2 хувийг хүн гэмтсэн<sup>3</sup> осол эзэлж байна. Хүн гэмтсэн ослын 74.3 хувь, эд материалын хохиролтой ослын 91.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

<sup>1</sup> Зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг хэлнэ /Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль/.

<sup>2</sup> Эд материалын хохиролтой зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учруулахыг хэлнэ.

<sup>3</sup> Хүн гэмтсэн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн буруу хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирохыг хэлнэ.

Зураг 1.2. Бүртгэгдсэн зам тээврийн осол, 2017 он



Улаанбаатар хотод бүртгэгдсэн зам тээврийн ослын 91.0 хувь нь мөргөлдөх, 6.7 хувь нь явган хүн дайрах хэлбэртэй байхад орон нутагт 63.6 хувь нь мөргөлдөх, 18.2 хувь нь онхолдох хэлбэртэй байна.

Хүснэгт 1.1. Бүртгэгдсэн зам тээврийн осол, ослын хэлбэрээр, 2017 он


Хэлбэр	Улсын хэмжээ		Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>36 591</b>	<b>100.0</b>	<b>32 662</b>	<b>100.0</b>	<b>3 929</b>	<b>100.0</b>
Мөргөлдөх	32 214	88.1	29 719	91.0	2 495	63.6
Явган хүн дайрах	2 523	6.9	2 189	6.7	334	8.5
Үл хөдлөх зүйл мөргөх	670	1.8	479	1.5	191	4.9
Онхолдох	850	2.3	133	0.4	717	18.2
Мал, амьтан дайрах	155	0.4	28	0.1	127	3.2
Зорчигч унагах	34	0.1	14	-	20	0.5
Дугуйтай хүн мөргөх	85	0.2	77	0.2	8	0.2
Бусад	60	0.2	23	0.1	37	0.9

Улсын хэмжээнд 2017 онд 815009<sup>4</sup> автомашин замын хөдөлгөөнд оролцож байгаа нь 1991 оноос 18.7 дахин, 2010 оноос 3.2 дахин, 2016 оноос 6.4 хувиар нэмэгдсэн байна.

<sup>4</sup> Авто тээврийн газрын Зам тээврийн хяналт, бүртгэлийн газрын мэдээлэл


Дараах зурагт автомашины тоог төрлөөр харуулав /Зураг 1.3/.

Зураг 1.3. Автомашины тоо, төрлөөр




Дүргүүдээс Баянзүрх дүүрэгт хамгийн олон буюу 109.4 мянган автомашин байна.

Зураг 1.4. Автомашин, дүүргээр, 2017 он



Зам тээврийн осол гаргасан тээврийн хэрэгслийг төрлөөр авч үзвэл 2017 онд 92.5 хувийг суудлын машин эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 1.5. Зам тээврийн нийт осол гаргасан тээврийн хэрэгсэл, дүнд эзлэх хувиар, төрлөөр, 2016-2017 он




Мотоциклээр үйлдэгдсэн зам тээврийн нийт 390 осол бүртгэгдсэний 78.7 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Нийслэлд гарсан зам тээврийн ослын 71.8 хувь нь баруун талдаа жолооны хүрдний байрлалтай байна.

Хүний амь нас хохирсон ослыг сараар авч үзэхэд, 7 дугаар сард хамгийн их бүртгэгдсэн нь тухайн сард хүмүүс амралт, аялал, зугаалгаар хөдөө, орон нутаг руу их явдагтай холбоотой байх талтай.

Зураг 1.6. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо, сараар, 2017 он



Улсын хэмжээнд 2017 онд жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс зам тээврийн 793 осол гарч, өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар буурав. Нийт ослын 41.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

## 1.1 Зам тээврийн ослын шалтгаан

Зам тээврийн ослын шалтгааныг дараах байдлаар ангилдаг . Үүнд:

- ✓ Жолоочийн буруутай үйлдэл
- ✓ Явган зорчигчийн буруутай үйлдэл
- ✓ Замын нөхцөл
- ✓ Техникийн гэмтэл

Улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын 97.5 хувь нь жолоочийн буруугаас, 2.4 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 0.1 хувь нь замын нөхцлөөс болсон бөгөөд өмнөх оны мөн үеэс жолоочийн буруутай үйлдлийнх 0.2 пунктээр нэмэгдэж, явган зорчигчийн буруутай үйлдлийнх 0.2 пунктээр буурч, замын нөхцлөөс болсон осол өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

- ✓ **Жолоочийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн ослын голлох шалтгааны эзлэх хувийг харуулбал:**
  - Хажуу хоорондын зай тохируулаагүйгээс -43.4 %
  - Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн -15.3 %
  - Эгнээ байр буруу эзэлсэн – 14.8 %
  - Ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн – 8.2 %
  - Хурд хэтрүүлсэн – 2.3 %
  - Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон -2.2 %

Жолоочийн буруутай үйлдлийн улмаас бүртгэгдсэн ослын шалтгаан Улаанбаатар хот болон орон нутгийн замд ялгаатай байна.


Улаанбаатар хотод	Орон нутагт
Хажуу хоорондын зай тохируулаагүй-48.6%	Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон- 20.2%
Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн-16.5%	Зогсоох арга хэмжээ аваагүй - 16.3%
Эгнээ байр буруу эзэлсэн- 16.5%	Хажуу хоорондын зай тохируулаагүй-9.9%
Ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн- 8.3%	Хурд хэтрүүлсэн-9.1%
Зогсоох арга хэмжээ аваагүй -2.1%	Ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн - 9.0%
Анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон-2.0%	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон-8.5%
Бусад-6.0%	Бусад-27.0%

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарсан осол өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар буурсан хэдий ч өнгөрсөн онд нийт ослын 1.8 хувийг эзэлж байсан бол 2017 онд 2.2 хувийг эзэлж байна.

Хурд хэтрүүлсэн осол өнгөрсөн оны мөн үеэс 19.9 хувиар өсөж, өнгөрсөн онд нийт ослын 1.5 хувийг эзэлж байсан бол 2017 онд 2.3 хувийг эзэлж байна.

Хурд хэтрүүлсэн зам тээврийн ослын 42.1 хувь нь орон нутгийн зам дээр гарсан байна.

Зураг 1.7. Хурд хэтрүүлсэнээс гарсан зам тээврийн осол, аймаг, дүүргээр, 2017 он



✓ **Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарах осол дараах шалтгаантай байдаг. Үүнд:**

- Явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах,
- Гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах,
- Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх

- Зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох,
- Замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах,
- Согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсгээр явах, хэвтэх,
- Замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах,
- Замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох /зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, захиа бичих, чихэвчний хөгжим сонсох/,
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /Эцэг, эх, асран хамгаалагчийн буруугаас/ зэргээс автомашинд дайрагдах, мөргөгдөх.

**Явган зорчигч<sup>5</sup>** гэж замаар явган яваа /зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаагаас бусад/ хүнийг хэлнэ.

**Замын хөдөлгөөнд оролцогч<sup>6</sup>** гэж замаар яваа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгслээр зорчигчийг хэлнэ. Явган зорчигч жолоочийн нэгэн адил замын хөдөлгөөнд оролцогч юм.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 88.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Нийт явган зорчигчийн буруутай үйлдлээс бүртгэгдсэн ослын 32.9 хувийг явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоны улмаас, мөн сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулсанаас болсон осол 7.3 хувийг эзэлж байна.

✓ **Замын нөхцлөөс гарах ослын голлох шалтгаан:**

- Замын гадаргуу, нөхцөл
- Замын гэрэлтүүлэг
- Замын тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжгүй байснаас

Замын нөхцлөөс шалтгаалан гарсан ослын 59.1 хувь нь Улаанбаатар хотод, 40.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Замын эвдрэл, гэмтэл нь Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол гарах шалтгаан нөхцлүүдийн нэг болдог байна.

<sup>5</sup> Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

<sup>6</sup> Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм




## ✓ Техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол:

Техникийн гэмтэл сааталд жолоочоос хамааралгүй техникийн гэмтэл, тухайлбал жолооны хүрд гацах, тоормос гэнэт барихгүй болох, гэрэл дохионы саатал, хөдөлгүүрийн гэмтэл гэх зэргийг хамруулна. Техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол 2017 онд бүртгэгдээгүй байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар жил бүр 1.2 сая хүн зам тээврийн ослоор нас барж, 50 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болох төлөвтэй байна гэсэн үр дүн гарсан байна.

Зураг 1.8. Дэлхийн хэмжээнд зам тээврийн ослын улмаас нас барсан хүн



Эх үүсвэр: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

### 1.2 Зам тээврийн ослын улмаас хохирсон хүн

Зам тээврийн ослын улмаас 2017 онд нийт 5219 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна.

#### 1.2.1 Нас барсан хүн

Улсын хэмжээнд 2017 онд хүний амь нас хохирсон зам тээврийн осол 438 бүртгэгдэж, ослын улмаас<sup>7</sup> нийт **507** хүн нас барсан нь өмнөх оны мөн

<sup>7</sup> Зам тээврийн ослын улмаас нас барсан хүнд зам тээврийн ослын улмаас газар дээрээ болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нас барсан хүнийг оруулна.

үеэс 5.8 хувиар нэмэгдсэн байна /Зураг 1.9/. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүмүүсийн 77.9 хувь нь орон нутгийн зам дээр нас баржээ.




“Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

“Зорилт 3.6”-д 2020 он гэхэд замын хөдөлгөөний ослын улмаас нас барсан, гэмтэж бэртсэн хүний тоог хоёр дахин бууруулах зорилт тавьсан байна.




2017 оны 3 дугаар сард НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд “3.6.1” буюу 100 000 хүнд ногдох зам тээврийн ослоос шалтгаалсан нас баралтын түвшин улсын хэмжээнд 2017 онд 16.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 1.9. 100 000 хүнд ногдох зам тээврийн ослоос шалтгаалсан нас баралтын түвшин /ТХЗ-ын 3.6.1/, зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2017 оны мэдээллээр Монгол Улс 100000 хүнд ногдох зам тээврийн ослоос шалтгаалсан хүн амын нас баралтын түвшингээр дэлхийн 183 орноос 75-т орж байна.

Зураг 1.10. 100 000 хүнд ногдох зам тээврийн ослоос шалтгаалсан хүн амын нас баралтын түвшин, орнуудаар, 2017 он




Rank	Country	Rate	Rank	Country	Rate	Rank	Country	Rate
1	ZIMBABWE	75.02	62	VIET NAM	23.60	123	GEORGIA	10.68
2	SAO TOME	47.90	63	KAZAKHISTAN	23.26	124	UZBEKISTAN	10.54
3	RWANDA	46.59	64	GUATEMALA	22.55	125	BAHAMAS	10.42
4	LIBERIA	46.20	65	HONDURAS	22.52	126	ARAB EMIRATES	10.39
5	BURUNDI	45.95	66	TUNISIA	22.51	127	UNITED STATES	10.04
6	UGANDA	45.69	67	INDIA	22.51	128	MOLDOVA	9.90
7	MOZAMBIQUE	44.52	68	SOUTH AFRICA	22.46	129	AZERBAIJAN	9.78
8	GAMBIA	43.85	69	IRAQ	22.34	130	JAMAICA	9.75
9	TANZANIA	43.56	70	KYRGYZSTAN	22.28	131	UKRAINE	9.11
10	MALAWI	43.10	71	BOTSWANA	22.23	132	SOUTH KOREA	9.05
11	VENEZUELA	42.18	72	BRAZIL	21.96	133	MONTENEGRO	9.01
12	COMOROS	41.83	73	KUWAIT	21.27	134	LATVIA	8.85
13	MADAGASCAR	40.55	74	ECUADOR	21.22	135	TURKEY	8.85
14	BURKINA FASO	39.57	75	MONGOLIA	20.89	136	CROATIA	8.22
15	TOGO	39.30	76	NEW GUINEA	20.89	137	BRUNEI	8.05
16	KENYA	39.22	77	TAJIKISTAN	20.68	138	BAHRAIN	8.04
17	SENEGAL	38.40	78	CAMBODIA	20.50	139	POLAND	7.93
18	SOUTH SUDAN	37.80	79	NEPAL	20.13	140	ROMANIA	7.89
19	BENIN	37.57	80	MYANMAR	20.10	141	SEYCHELLES	7.79
20	ERITREA	37.37	81	MOROCCO	19.75	142	SLOVAKIA	7.30
21	DR CONGO	36.88	82	NORTH KOREA	19.67	143	TONGA	7.02
22	ETHIOPIA	36.36	83	EL SALVADOR	19.50	144	MACEDONIA	7.02
23	SOMALIA	35.88	84	TIMOR-LESTE	19.34	145	GREECE	7.00
24	ZAMBIA	35.43	85	SAMOA	19.23	146	GREYNADE	6.72
25	NIGER	35.37	86	LEBANON	19.22	147	LUXEMBOURG	6.71
26	SIERRA LEONE	35.37	87	HATTI	19.21	148	BELGIUM	6.61
27	SUDAN	35.23	88	SURINAME	19.14	149	CUBA	6.50
28	CAMEROON	35.06	89	COLOMBIA	18.82	150	BULGARIA	6.40
29	CENTRAL AFRICA	35.05	90	AFGHANISTAN	18.73	151	SERBIA	6.38
30	GUINEA	34.95	91	VANUATU	18.42	152	HUNGARY	6.22
31	GHANA	33.17	92	SAINT LUCIA	18.37	153	PORTUGAL	6.11
91	VANUATU	18.42	152	HUNGARY	6.22			
92	SAINT LUCIA	18.37	153	PORTUGAL	6.11			
93	TURKMENISTAN	17.64	154	FIJI	6.10			
94	CHINA	17.50	155	CZECH REPUBLIC	5.97			
95	INDONESIA	16.64	156	ESTONIA	5.94			
96	NICARAGUA	16.56	157	SLOVENIA	5.75			
97	URUGUAY	16.49	158	NEW ZEALAND	5.74			
98	SRI LANKA	16.33	159	CYPRUS	5.65			
99	LAOS	16.13	160	CANADA	5.26			
100	BHUTAN	15.91	161	BARBADOS	5.09			
101	GUYANA	15.88	162	AUSTRALIA	4.94			
102	RUSSIA	15.85	163	FRANCE	4.86			
103	BAKLANDESH	15.56	164	AUSTRIA	4.74			
104	PAKISTAN	15.42	165	ITALY	4.72			
105	QATAR	14.92	166	MALTA	4.62			
106	SAINT VINCENT	14.54	167	MALDIVES	4.03			
107	ARMENIA	14.52	168	IRELAND	4.01			
108	EGYPT	14.46	169	FINLAND	3.73			
109	COSTA RICA	14.32	170	GERMANY	3.54			
110	PERU	14.01	171	ICELAND	3.27			
111	ARGENTINA	13.39	172	ISRAEL	3.27			
112	BOSNIA/HERZEG.	12.65	173	SINGAPORE	3.24			
113	TRINIDAD/TOB.	12.52	174	JAPAN	3.04			
114	ALBANIA	12.32	175	SPAIN	2.94			
115	MEXICO	12.13	176	NORWAY	2.93			
116	PHILIPPINES	11.82	177	DENMARK	2.89			
117	MAURITIUS	11.81	178	SWITZERLAND	2.82			
118	LITHUANIA	11.34	179	NETHERLANDS	2.81			
119	ANTIGUA/BAR.	11.21	180	UNITED KINGDOM	2.58			
120	BELARUS	11.16	181	KIRIBATI	2.57			
121	PANAMA	10.84	182	SWEDEN	2.49			
122	CHILE	10.74	183	MICRONESIA	2.34			

Эх үүсвэр: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүмүүсийн 92.6 хувь нь 24 цагийн дотор, 7.1 хувь нь 30 хоногт, 0.3 хувь нь 30-аас дээш хоногт нас барсан байна. Амь насаа алдсан хүмүүсийн зөвхөн 8.4 хувь нь эмнэлгийн анхны тусламж авсан байна. Эмнэлгийн анхны тусламж авч чадаагүй тохиолдол өндөр байгаа нь орон нутгийн замд төв, суурин газраас алслагдсан замуудад хүний амь нас хохирсон осол бүртгэгдсэнтэй холбоотой юм /Зураг 1.11/.


Зураг 1.11. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, аймаг, нийслэлээр, 2017 он



Улсын хэмжээнд 850 тээврийн хэрэгсэл онхолдсоноос 189 хүний амь нас хохирсоны 176 буюу 93.1 хувийг орон нутгийн замд гарсан осол эзэлж байна.

2017 онд зам тээврийн ослын улмаас нас барсан хүмүүсийн 46.2 хувь нь толгойдоо гэмтэл авч амь насаа алдсан байна.


Зураг 1.12. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний гэмтэл авсан байдал, 2017 он



Мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас 54 хүний амь нас хохирч, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурч, дийлэнхи нь толгойндоо авсан гэмтэл үхэлд хүргэх шалтгаан болсон байна. Нийт хүмүүсийн 92.6 хувь нь орон нутгийн замд амь насаа алдсан байна. Мотоциклоор замын хөдөлгөөнд оролцож буй тохиолдолд хамгаалалтын малгай өмсөж хэвшихэд үхэлд хүргэх эрсдэл 40 хувиар буурна гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан байна.

Зам тээврийн ослын улмаас нас баралтын олон жилийн динамик тоонд үндэслэн 2018-2020 оны төлөв байдлыг тооцлоо /Зураг 1.13/. Энэхүү төлөв байдлаас харахад зам тээврийн ослын улмаас нас баралт 2020 он гэхэд 2016 оноос 36.7 хувиар өсөх магадлалтай харагдаж байна.

Зураг 1.13. Зам тээврийн ослын улмаас нас баралтын 2018-2020 оны төлөв байдал




### 1.2.2 Гэмтсэн хүн

Улсын хэмжээнд 2017 онд зам тээврийн ослын улмаас<sup>8</sup> нийт **4712** хүн хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл бэртэл авсан нь өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна /Зураг 1.14/. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүмүүсийн 77.7 хувь нь Улаанбаатар хотын зам дээр гэмтсэн байна.

<sup>8</sup> Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүнд зам тээврийн осолд өртөж их бага, тодорхой хэмжээгээр бэртэл, гэмтэл авсан /тухайлбал, зөөлөн эдийн гэмтэл, шарх авсан, шалбарсан, зулгарсан гэх мэт/ хүнийг хамааруулна.

Зураг 1.14. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн, аймаг, нийслэлээр, 2017 он



Жолооч, зорчигчид суудлын хамгаалах бүс хэрэглэх нь ослын үед гарах гэмтэл, хор уршгаас сэргийлэхэд нэн чухал үүрэгтэй хэрэгсэл байдаг. Гэвч 2017 онд зам тээврийн осолд өртсөн жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчдын 62.1 хувь нь хамгаалах бүсээ хэрэглээгүй, 13.7 хувь нь хэрэглэсэн, 24.2 хувь нь хэрэглэсэн эсэх нь тогтоогдоогүй байна.

Хүснэгт 1.2. Зам тээврийн осолд орж амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүмүүсийн хамгаалах бүсний хэрэглээ, дүнд эзлэх хувиар


Он	Хэрэглэсэн	Хэрэглээгүй	Тогтоогдоогүй
2013	3.9	76.5	19.6
2014	26.9	56.0	17.1
2015	12.7	74.7	12.6
2016	19.1	64.4	16.5
2017	13.7	62.1	24.2

Орон нутгийн замд гарсан ослын улмаас амь насаа алдсан жолооч, зорчигчийн 82.5 хувь нь хамгаалах бүсээ хэрэглээгүй, түүнчлэн зорчигч хүүхдүүдэд зориулалтын хамгаалалтын суудал хэрэглэж заншаагүйгээс ослоос авсан гэмтэл нь амь насаа алдахад хүргэсэн байна. Автомашин урд хэсгээрээ мөргөлдөх үед хүмүүс их гэмтдэг болохыг эрдэмтэд тогтоогоод, хамгаалах бүсийг зөв хэрэглэвэл урд суудалд сууж явсан хүний 40-50 хувиар, хойд суудалд сууж явсан хүнийг 70-75 хувиар осол гэмтлээс бүрэн хамгаалдаг гэж үздэг байна.

### 1.2.3 Зам тээврийн осол гаргасан жолооч

Нийт зам тээврийн осол үйлдсэн жолоочийн жолоо барих эрх авсанаас хойших хугацаагаар харуулбал 34.1 хувь нь 0-5 жил болсон байна.

Зураг 1.15. Зам тээврийн осол гаргасан жолооч, жолоо барих эрх авсанаас хойших хугацаагаар, 2017 он





## 2. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг


ЦЕГ-ын мэдээллээр улсын хэмжээнд 2017 онд нийт 32259 гэмт хэрэг бүртгэгдсэний 4.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Дараах зургаас харахад суудлын машины тоо тасралтгүй өсч байгаа боловч ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг нь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна.

Зураг 2.1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, суудлын машины тоо




18, түүнээс дээш насны 100 000 хүнд ногдох ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 2000 онд хамгийн өндөр байна.

Зураг 2.2. 18, түүнээс дээш насны 100 000 хүнд ногдох ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг




Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн улирлаар нь авч үзвэл 34.9 хувь нь намар, 32.5 хувь нь зун бүртгэгдсэн байна.

Зураг 2.3. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, улирал, дүнд эзлэх хувиар, 2017 он



Зураг 2.4. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон газрын байршил, 2017 он



## 2.1 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүн

Хүний амь нас хохирсон 115 зам тээврийн ослыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (хуучин Эрүүгийн байцаан шийтгэх хууль)-ийн холбогдох зүйл заалтаар хэрэгсэхгүй болгосноор ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас **392** хүн нас барсан байна. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүний 318 (81.1%) нь орон нутагт, 74 (18.9) нь Улаанбаатар хотод байна.


18, түүнээс дээш насын 100 000 хүнд ногдох ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүн 2017 онд 19 болж, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 2.1. 18, түүнээс дээш насны 100 000 хүнд ногдох ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүн, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017
<b>Улсын дүн</b>	27	24	25	22	18	22	20	19
<b>Баруун бүс</b>	23	21	17	15	11	14	20	17
Баян-Өлгий	12	29	21	8	8	4	26	7
Говь-Алтай	27	16	21	15	11	8	14	16
Завхан	23	7	13	8	-	9	11	17
Увс	34	34	17	36	9	17	8	10
Ховд	23	20	16	9	28	32	38	37
<b>Хангайн бүс</b>	27	20	17	12	15	22	21	23
Архангай	29	6	17	13	12	30	22	41
Баянхонгор	25	23	17	26	19	15	19	22
Булган	29	33	22	14	36	37	37	31
Орхон	46	13	12	12	8	12	4	7
Өвөрхангай	21	26	17	14	14	21	30	19
Хөвсгөл	23	24	18	1	9	21	20	22
<b>Төвийн бүс</b>	30	35	33	33	27	50	45	41
Говьсүмбэр	-	16	-	26	11	49	19	74
Дархан-Уул	48	21	34	17	11	27	15	12
Дорноговь	18	12	21	13	18	76	60	28
Дундговь	17	30	31	13	0	72	27	66
Өмнөговь	30	18	24	25	27	38	47	43
Сэлэнгэ	31	28	40	30	37	44	47	42
Төв	26	72	40	80	54	62	78	60
<b>Зүүн бүс</b>	23	24	13	18	24	33	28	40
Дорнод	14	31	5	13	12	26	12	29
Сүхбаатар	37	14	16	18	14	18	23	53
Хэнтий	23	23	20	23	47	54	49	39
<b>Улаанбаатар</b>	28	23	32	27	17	12	10	8

ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас барсан хүмүүсийг замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрээр нь авч үзвэл орон нутагт 42.1 хувийг тээврийн хэрэгслээр зорчигч, харин Улаанбаатар хотын хувьд 59.5 хувийг явган зорчигч эзэлж байна.

Зураг 2.1. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр, 2017 он



Зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадлагаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн **1135** хүн байна. Эдгээр гэмтсэн хүмүүсийн 58.2 хувь нь хүндэвтэр, 27.2 хувь нь хүнд, 14.6 хувь нь хөнгөн гэмтэл авсан байна. Нийт гэмтсэн хүмүүсийн 50.7 хувь нь орон нутгийн зам дээр гэмтсэн байна.


18, түүнээс дээш насын 100000 хүнд ногдох ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 2017 онд 56 болж, өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 2.3. 18, түүнээс дээш насны 100 000 хүнд ногдох ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017
<b>Улсын дүн</b>	60	72	119	66	51	70	63	56
<b>Баруун бүс</b>	36	40	49	19	26	32	32	30
Баян-Өлгий	12	71	36	2	19	21	19	18
Говь-Алтай	55	21	51	25	17	19	58	27
Завхан	34	26	33	29	11	36	24	34
Увс	43	50	39	25	32	32	22	25
Ховд	45	37	88	17	50	51	46	46
<b>Хангайн бүс</b>	64	34	55	38	41	50	39	37
Архангай	45	13	71	41	56	43	47	30
Баянхонгор	56	54	44	42	41	40	30	25
Булган	33	30	53	65	48	57	52	53
Орхон	193	65	72	29	69	64	37	41
Өвөрхангай	71	22	56	49	31	62	54	47
Хөвсгөл	35	35	38	15	17	38	23	30
<b>Төвийн бүс</b>	42	72	111	77	41	88	86	91
Говьсүмбэр	-	32	29	26	21	88	67	130
Дархан-Уул	63	54	76	68	30	58	65	43
Дорноговь	58	85	102	100	52	88	84	78
Дундговь	37	41	79	36	3	76	44	43
Өмнөговь	35	58	77	46	24	71	64	108
Сэлэнгэ	24	49	111	94	58	90	113	133
Төв	36	125	186	100	59	135	119	108
<b>Зүүн бүс</b>	48	31	58	23	27	68	48	45
Дорнод	69	62	75	13	34	93	59	45
Сүхбаатар	24	-	26	18	6	45	41	58
Хэнтий	45	21	66	38	36	60	43	35
<b>Улаанбаатар</b>	90	134	217	103	71	83	75	60

ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүмүүсийг замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрээр нь авч үзвэл орон нутагт 42.5 хувийг, харин Улаанбаатар хотод 58.1 хувийг явган зорчигч эзэлж байна.

Зураг 2.2. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр, 2017 он




## 2.2 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдогч

2017 онд ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэгт 1273 хүн холбогдож, өмнөх оны мөн үеэс 659 (34.1%)-өөр буурсан байна. Тэдний 57.1 хувийг 18-34 насны залуучууд эзэлж байна.


Гэмт хэрэгт холбогдогчдын 48.7 хувийг ажилгүй иргэд эзэлж байна.

Зураг 2.3. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэгт холбогдогч, нийгмийн байдлаар, дүнд эзлэх хувиар, 2016-2017 он



Гэмт хэрэгт холбогдогчдын 48.2 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг 2.4. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэгт холбогдогч, боловсролын түвшингээр, дүнд эзлэх хувиар, 2016-2017 он




### 3. Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Улсын хэмжээнд 2017 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 1018, үүнээс ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 241 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс ослын тоо 6.3 хувиар, гэмт хэргийн тоо 12.0 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн ослыг цагаар авч үзвэл осол 18-19 цаг, 13-14 цагийн хооронд өндөр байгаа нь хүүхдүүд хичээл цуглах, тарах цагт замын хөдөлгөөнд оролцож байгаа учраас зам тээврийн осолд их өртдөг байна.

Зураг 3.1. Хүүхэд өртсөн зам тээврийн осол, цагаар, 2017 он






Зам тээврийн ослын улмаас улсын хэмжээнд амь насаа алдсан **55** хүүхэд, гэмтэж, бэртсэн **1058** хүүхдийн 186 нь хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. Нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 5 (10.0%)-аар нэмэгдэж, гэмтсэн хүүхдийн тоо 7 (0.7%) -гоор буурсан байна.

Хүснэгт 3.1. Зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүүхэд

	Он	Нийт		
		Орон нутагт	Улаанбаатар хотод	
Нас барсан	2005	54	27	27
	2006	36	28	8
	2007	32	23	9
	2008	40	27	13
	2009	36	27	9
	2010	28	18	10
	2011	40	26	14
	2013	37	27	10
	2014	48	38	10
	2015	54	42	12
	2016	50	45	5
	2017	55	46	9
	Гэмтсэн	2005	646	121
2006		851	53	798
2007		795	30	765
2008		602	65	537
2009		538	54	484
2010		656	45	611
2011		935	59	876
2013		1 231	81	1 150
2014		1 164	95	1 069
2015		1 089	91	998
2016		1 065	95	970
2017		1 058	138	920

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүдийн 43.2 хувийг 7-14 насны хүүхдүүд, 60.7 хувийг эрэгтэй хүүхдүүд эзэлж байна.


Зураг 3.1. Зам тээврийн осолд өртсөн хүүхэд, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2016-2017 оноор



Дээрх графикаас харахад Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13.2.7-д “Эцэг, эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх” гэж зааж өгсөн боловч эцэг, эх, асран хамгаалагчид хуулинд заасан үүргээ биелүүлэхгүй байгааг харуулж байна.


Орон нутагт зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 72.8 хувийг, харин Улаанбаатар хотод осолд өртсөн хүүхдүүдийн 68.7 хувийг явган зорчигчид эзэлж байна.

Зураг 3.2. Зам тээврийн осолд өртсөн хүүхэд, хөдөлгөөнд оролцсон хэлбэрээр, 2017 он



ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 2016 оноос 5 (10.0%)-аар нэмэгдэж, харин гэмтсэн хүүхдийн тоо 58 (17.0%)-аар буурчээ. ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас нийт нас барсан хүүхдүүдийн 46 (83.6%) нь орон нутгийн замд, гэмтсэн хүүхдүүдийн 108 (58.1%) нь Улаанбаатар хотод хүнд, хүндэвтэр гэмтэл авсан байна.

Зураг 3.3. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүүхэд, аймаг, нийслэлээр, 2017 он



## ДҮГНЭЛТ

Зам тээврийн ослын хамгийн хүнд үр дагавар бол хүний эрүүл мэнд, амь нас хохирох явдал юм. Монгол Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 2017 онд 507 хүн нас барсан байна. Эдгээр нас барсан хүмүүсийн 77.9 хувь нь орон нутгийн зам дээр нас барсан байна.

Улсын хэмжээнд 850 тээврийн хэрэгсэл онхолдсоноос 189 хүний амь нас хохирсон ба тэдгээрийн 176 буюу 93.1 хувь нь орон нутгийн замд осолдсон байна. Мөн хурд хэтрүүлсэний улмаас гарсан ослийн 42.1 хувь, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарсан ослын 41.0 хувь нь орон нутгийн зам дээр гарсан байна. Эдгээр тоо мэдээллээс харахад жолооч нар орон нутгийн замд явахдаа хурд хэтрүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсний улмаас амь насаа алдаж байна.

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ын “3.6.1” буюу 100 000 хүнд ногдох зам тээврийн ослоос шалтгаалсан нас баралтын түвшин Монгол Улсын хэмжээнд 2017 онд 16.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр нэмэгдсэн байна. Энэхүү үзүүлэлтийг бууруулахын тулд зам тээврийн ослын үед хэн хохирогч болж байгаа, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан судалж, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хор уршгийг багасгах арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байна.

Улаанбаатар хотод зам тээврийн осолд өртөж хохирсон хүмүүсийн 58.6 хувийг явган зорчигчид эзэлж байгаа нь хүмүүсийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, мэдсэн ч дүрмээ биелүүлдэггүй байдал, тэдэнд оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас амь насаа алдах, бэртэл, гэмтэл авч хохирсоор байна.

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүүхдүүдийн 83.6 хувийг орон нутагт бүртгэгдсэн осол эзэлж байна.

Хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг бол автомашин доторх аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүүхдийн зориулалтын хамгаалах бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвших явдал юм.

Улаанбаатар хотод зам тээврийн осолд өртсөн хүүхдүүдийн дийлэнх нь явганаар замын хөдөлгөөнд оролцогч хүүхдүүд байгаа нь хүүхдүүдэд замын хөдөлгөөний мэдлэг, замын хөдөлгөөнд зөв оролцох дадал

хэвшээгүйтэй холбоотой гэж үзэж байна. Иймд сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдэд Замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, замын хөдөлгөөний боловсролыг олгож, зөв оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх шаардлагатай байна.

2017 онд зам тээврийн осолд өртсөн жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчдын зөвхөн 13.7 хувь нь хамгаалах бүс хэрэглэсэн байжээ. Зам тээврийн осол гарах үед хамгаалах бүс хэрэглээгүй хүмүүсийн 32 хувь нь нуруу, 50-аас дээш хувь нь толгой, нуруундаа гэмтэл авч хамар, эрүү, эгэмний яс хугарч, дух нүүрний хэсэг нь зүсэгддэг байна.

Замын хөдөлгөөний дүрмийг хэрэгжүүлэх нь зөвхөн жолоочид биш, замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчид ч хамааралтайг Зөрчлийн тухай хууль /14.7/, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэмд заасан боловч хүмүүс хууль дүрмээ мөрдөхгүйгээс зам тээврийн осолд өртсөөр байна.

Улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын 97.5 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс, 0.1 хувь нь замын нөхцлөөс болсон байна.

Манай орны зам хангалттай сайн биш байхад замын нөхцлийн улмаас гарсан ослын тоо маш бага байгаа нь замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцлийг тойрох зорилгоор автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулдагтай холбоотой байна.

Иймд замын нөхцлөөс шалтгаалсан зам тээврийн ослын хохирлыг зам, байгууламжийг хариуцсан байгууллага, аж ахуйн нэгжид бүрэн хариуцуулдаг болговол замын нөхцөл сайжрах нэг нөхцөл болно гэж үзэж байна.

Зам тээврийн ослыг бууруулахын тулд хурд хэтрүүлэх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг бууруулах, мотоциклын хамгаалалтын малгай, суудлын даруулга, хүүхдийн хамгаалалтын хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагууд зохих арга хэмжээнүүдийг тууштай авч хэрэгжүүлж, зохион байгуулах шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

14200 Улаанбаатар, Монгол Улс, Засгийн Газрын III байр,

И-Мэйл: [information@nso.mn](mailto:information@nso.mn),

<https://www.facebook.com/StatisticMongolia/>,

[http://twitter.com/statistic\\_mn](http://twitter.com/statistic_mn),

Утас: 1900-1212, 51-264554